

Article

Participation of Imprisoned Citizens in Elections and Its Implementation

Unubold Erdenetsog*

Department of Security, School of Court Decision Enforcement, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: Unubold4work@gmail.com

 <https://orcid.org/0009-0002-0493-9528>

Received: 02 March 2026. Accepted: 21 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

The ideological foundation of Mongolia's Constitution fully expresses our country's development, social goals, and objectives. These goals and objectives essentially lie in establishing the vital value of human rights in society through properly regulating the relationship between citizens and the state.

Therefore, ensuring equal participation and seeking opportunities for people in all sectors and relations of society is necessary, and this is what the state must do first and foremost. However, essential necessity and justification are the main factors in establishing limitations on human rights.

Yet, due to our narrow understanding and traditional attitudes when viewing many sectors of social relations, numerous conditions giving rise to human rights violations continue to form and exist. The purpose of this paper is directed at introducing to readers and providing information about issues and causes we have overlooked, by making conclusions based on the ideological foundation of the Constitution regarding these conditions and determining solutions. Claude is AI and can make mistakes. Please double-check responses.

This concerns the issue of imprisonment procedures and the right to vote and be elected. People serving prison sentences do not have the right to participate in elections, which is explained as being related to having committed a crime. However, having committed a crime cannot be a complete and sufficient reason to restrict this right, and even though one type of crime specified in the criminal code was committed, depending on the chosen sanction to be imposed, one person may be sentenced to a fine while another is sentenced to imprisonment.

Therefore, the reason of having committed a crime cannot be a direct basis or reason for restricting the right to participate in governing the state, the right to vote and be elected. I developed this paper based on legal scientific research methodology with the aim of explaining this reasoning and expressing the researcher's position.

To achieve the purpose of the paper, I used dialectical and general methods of legal science. In doing so, based on the observational method, I hypothesized about violations of the right to participate in elections for people serving prison sentences, and employed dialectical methods to prove this hypothesis. Specifically, I analyzed and examined the ideological foundation of the Constitution using analytical methods and identified the features contained within it. Through a systematic approach, I assessed and explained the ideological foundation of the Constitution, democratic elections, and the nature of imprisonment.

Finally, using logical methods, I arrived at the following conclusions and hypotheses: The fundamental rights and freedoms of citizens under Mongolia's Constitution apply to all people, and the only grounds for restricting them are national and public security and public order.

Nevertheless, the legal instruments that have restricted the rights of people serving prison sentences may be traditional attitudes, and I concluded that the electoral laws' exclusion of the right of people serving prison sentences to participate in elections conflicts with the content and ideological foundation of the Constitution.

Keywords: Democracy, state, human rights, prisoner, election, participation, crime.



©2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуульд оролцох, түүний хэрэгжилт

Эрдэнэцогтын Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, Аюулгүй байдлын тэнхим, Улаанбаатар хот, Монгол Улс

Хураангуй

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал бол манай улсын хөгжил, нийгмийн зорилго, зорилтыг бүрэн илэрхийлдэг билээ. Энэхүү зорилго зорилт нь мөн чанартаа иргэн ба төрийн харилцааг оновчтой зохицуулах хэлбэрээр хүний эрх хэмээх амин чухал үнэт зүйлийг нийгэмд хэвшүүлэхэд оршиж байна.

Тэгвэл нийгмийн бүхий л салбар, харилцаанд хүмүүсийн оролцоог тэгш хангах, боломжийг эрэлхийлэх учиртай ба энэ бол төрийн нэн тэргүүнд хийж, гүйцэтгэх зүйл мөн. Гэхдээ зайлшгүй шаардлага, үндэслэл л хүний эрхийн хязгаарлалтыг тогтоох гол хүчин зүйл байдаг.

Гэтэл нийгмийн харилцааны олон салбарыг харах бидний өрөөсгөл ойлголт, уламжлалт хандлагуудтай холбоотойгоор хүний эрхийн зөрчил үүсэх олон нөхцөл бүрэлдэн тогтоод байна. Харин эдгээр нөхцөл байдалд Үндсэн хуулийн үзэл баримтлалд суурилсан дүгнэлт хийж, шийдлийг тодорхойлох замаар бидний үл анзаарч ирсэн асуудал, шалтгааныг уншигчдад таниулах, мэдээлэл өгөхөд илтгэлийн зорилго чиглэж байна.

Энэ бол хорих ял эдлүүлэх ажиллагаа ба сонгох, сонгогдох эрхийн асуудал юм. Хорих ял эдэлж байгаа иргэд сонгуульд оролцох эрхгүй бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотой гэж тайлбарладаг. Гэхдээ гэмт хэрэг үйлдсэн байх нь уг эрхийг хязгаарлах бүрэн дүүрэн шалтгаан болж чадахгүй ба эрүүгийн хуульд заасан нэг төрлийн гэмт хэргийг үйлдсэн хэдий ч түүнд хүлээлгэх сонгох санкцаас хамааран нэг хүн нь торгох ял шийтгүүлсэн бол нөгөө нь хорих ялаар шийтгүүлж байна.

Тэгэхээр гэмт хэрэг үйлдсэн гэдэг шалтгаан бол иргэний төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах шууд үндэслэл, шалтгаан болж чадахгүй байна.

Үүний шалтгааныг тайлбарлах, судлаачийн байр суурийг илэрхийлэх зорилгоор хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүйд суурилан илтгэлийг боловсрууллаа.

Илтгэлийн зорилгод хүрэхийн тулд хууль зүйн шинжлэх ухааны диалектик, ерөнхий аргуудыг ашигласан.

Ингэхдээ ажиглалтын аргад суурилан хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуульд оролцох эрхийн зөрчлийг таамагласан ба таамаглалаа нотлох үүднээс диалектикийн аргуудыг хэрэглэсэн. Тухайлбал үндсэн хуулийн үзэл баримтлалыг анализын аргаар задлан шинжилж түүнд агуулагдах шинжүүдийг тодорхойлсон. Системт хандлагыг аргаар үндсэн хуулийн үзэл баримтлал, ардчилсан сонгууль, хорих ялын мөн чанарыг дүгнэн тайлбарласан.

Эцэст нь логикийн аргуудыг ашиглан дараах дүгнэлт, таамаглалд хүрлээ. Үүнд: Монгол Улсын үндсэн хуулиар иргэний үндсэн эрх, эрх чөлөө нь бүх ард түмэнд хамаарах ба түүнийг хязгаарлах үндэслэл бол гагцхүү үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн дэг журам байдаг.

Гэсэн хэдий ч хорих ял эдэлж байгаа иргэдийн эрхийг хязгаарласан эрх зүйн арга хэрэгслүүд нь уламжлалт хандлага байж болох ба сонгуулийн тухай хуулиудаар хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуульд оролцох эрхийг хасаж байгаа нь үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалтай зөрчилдөж байгааг дүгнэсэн.

Түлхүүр үгс: Ардчилал, төр, хүний эрх, хоригдол, сонгууль, оролцоо, гэмт хэрэг.

Оршил

Шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх асуудал хүн төрөлхтний түүхэнд ихээхэн ярвигтай хийгээд маргаан бүхий сэдэв байж ирсэн. Учир нь хүн бүрийн итгэсэн зүйл, тухайн хүний хувьд үнэн бөгөөд шударга байдаг болохыг бид анзаарч мэдсэн.

Тэгвэл бид хэрхэн шударга ёсыг нэг мөр ойлгож, хэрэглэж, хүмүүсийн харилцааг тэнцвэржүүлэх билээ. Ийм л шалтгаанаар шударга ёс хэмээх ойлголт нь философи, эрх зүй, улс төрийн үзэл санаа, онолын төвд оршиж ирсэн юм.

Харин хүмүүсийн бүтээсэн шийдэл бол үндсэн хууль юм. Улс үндэстнүүд үндсэн хуулийг бүтээх замаар шударга ёсны үнэт зүйлсийг хуульчлан тунхаглаж, эрхэмлэн шүтэх болсон билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” хэмээн тунхагласан ба хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зорилгыг өнөөдрийн илтгэлийн гол санаа болгон өгүүлэх болно.

Нарийвчлан авч үзвэл хорих ял эдэлж байгаа иргэдийн эрх, түүний хэрэгжилтийн асуудлыг хөндөх юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулиар бататган бэхжүүлсэн хүний эрх, эрх чөлөө нь хүн бүрт хамааралтай хэдий ч нийгэм дэх тогтсон хандлагаар хорих ял эдлэгсдийн эрх, эрх чөлөөнд хатуурхсаар ирсэн билээ. Гэмт хэрэг болоод гэмт этгээдийн зан үйлийг бид шударга ёсны шалгуураар авч үзээд шийтгэх, ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хоригдлын эрхийн хязгаарлалт, түүнийг тогтоох болсон мөн чанар, үзэл санааг төдийлөн анхаарч судлаагүй өнөөг хүрчээ. Өөрөөр хэлбэл хязгаарлагдсан эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчил байгааг судална. Харин тэрхүү хязгаарлалт хэрхэн бий болсон тухай судлаагүй байгаа нь анхаарал татаж байна.

Үүний нэг томоохон илрэл бол хоригдлын сонгуульд оролцох эрх юм. Хүний эрхийг хязгаарлах хууль нь зайлшгүй шаардлага, үндэслэлд тулгуурлан хүний эрхийг хасах, хязгаарлах ёстой.

Гэтэл өнөөдөр хорих ял эдэлж байгаа 3000 гаруй Монгол Улсын иргэн байгаа бөгөөд эдгээр хүмүүс хуулиар эрхээ хязгаарлуулсан учир нийгмийн харилцаанд оролцох эрх нь хязгаарлалтын дотор бүрэн хэрэгжиж чадахгүй байна. Товчхондоо 3000 иргэний эрхийг ийм л байдаг, ийм л байсан, хуульд заасан хэмээн зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн үзэл санаа, агуулгад харшилж байгаа хэрэг юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал болон ардчилсан сонгуулийн зарчимд тулгуурлан хоригдлын сонгуульд оролцох эрхийн хэрэгжилтийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэх болно.

Илтгэлийг нэгдүгээрт Үндсэн хуулийн үзэл баримтлал дахь хүний эрх, эрх чөлөөний ойлголт, хоёрдугаар Ардчилсан сонгууль ба хүний эрх, эрх чөлөөний хамаарал, гуравдугаарт Хорих ял эдэлж байгаа иргэдийн ардчилсан сонгуульд оролцох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал гэсэн бүтэцтэйгээр боловсрууллаа.

Үндсэн хэсэг

Бид хүний эрхийг хангах, хамгаалах асуудлыг сүүлийн жилүүдэд идэвхтэй, судлан, эрдэм судлалын төвд авч ирээд байна. Үүний нэг томоохон салбар бол хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах асуудал болоод билээ. Гэхдээ хувь судлаачийн үзэж буйгаар асуудлын үндэс суурь, шалтгааныг онохгүй байна гэж үзэж байна. Үндсэн хуулиар бид хүний суурь эрхийг, иргэний үндсэн эрхийг заасан ба эдгээр нь хүн бүрт нэгэн жигд хамаарна. Энэ нь хоригдолд ч мөн адил хамаарах ёстой.

Гэтэл хорих ялын онцлог бол иргэний үндсэн хуульд заасан эрхийг хасах болон хязгаарладаг шинжтэй. Өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар (УИХ-ын Тамгын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) хоригдлын эрх буюу үндсэн хуульд заасан хүний эрхийн хязгаарлалтыг заадаг. Хэрэв ийнхүү хязгаарлалтыг илэрхийлж байгаа бол хязгаарлах болсон шалтгаан мөн чанар, зорилго нь хязгаарлалтай тохирч байх ёстой.

Хамгийн энгийн жишээг авч үзвэл сонирхолтой хандлага бий болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хоригдол эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих үүрэгтэй гэж заасан ба тус хуулийн дагуу “эрэгтэй хоригдол 0,3 сантиметрээс ихгүй халимаг үстэй байна” гэж хорих ангийн дотоод журамд заасан. Гэтэл эрүүгийн хариуцлага зорилготой “хүний үс” ямар уялдаатай болохыг бид анхаараагүй байна. Хоригдлын үсийг хусаж байгаа үйлдлийг бид ялын цээрлүүлэх чиг үүргийн хэрэгжилт гэж үзэж болохгүй. Түүхэн баримт сөхвөл 1936 онд тухайн үеийн нэршлээр Засан хүмүүжүүлэх байгууллага буюу хорих байгууллагад халдварт өвчин дэлгэрч болзошгүй тул ариун цэврийг сахиулах зорилгоор ял эдэлж байгаа хүмүүсийн үсийг хязгаарлах арга хэмжээ авч эхэлсэн байна (Э.Өнөболд, 2021). Үүнээс үзвэл тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь өдгөө эрүүгийн хариуцлагын цээрлүүлэлтийн арга хэрэгсэл болсон байгааг харж байна. Тэгвэл хоригдол хүний эрхийн хязгаарлалтууд нь үүнтэй адил шалтгаантай байж болох талтай байна. Эндээс Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаар тогтоосон хүний эрх, эрх чөлөөний мөн чанар алдагдаж байж болзошгүй.

Эдгээрийн нэг бол сонгууль өгөх эрхийн хэрэгжилт юм. Манай улсын хэмжээнд хорих ял эдэлж байгаа хүмүүс сонгууль өгөх, сонгуульд оролцох эрхээ эдэлж чадахгүй байна. Шалтгаан нь хорих ял эдэлж байгаа учраас.

Энэ шалтгаан бол иргэний сонгох, сонгогдох эрх, түүгээрээ дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох эрхийг хязгаарлах хангалттай үндэслэл болж чадахгүй байна. Учир нь хорих ял эдлүүлж байгаа нь тухайн хүнийг нийгмийн тодорхой хугацаагаар тусгаарлан хүмүүжүүлэх, тэдгээр хүмүүст нөлөөллийн онцгой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа илэрхийлж байгаагаас бус Монгол Улсын иргэнээс хасах, хорих ял эдэлж байгааатай нь холбогдуулан ялгаварлан, гадуурхах шалтгаан болж болохгүй. Товчхондоо бол нийгэмд бие даан хэвийн амьдрахад шаардлагатай дадал, хүмүүжил, хандлагыг олгоод, нийгэмд эргүүлэн нэгтгэхэд оршино. Харин энэхүү тусгаарлалт нь түүний иргэний эрх, эрх

чөлөөг хасах шалтгаан биш. Мөн чанартаа бол хорих ангид ялыг эдлүүлэхтэй холбогдсон зайлшгүй хязгаарлалтад үндэслэсэн эрхийн хязгаарлалт байх ёстой.

Иймд ардчилсан сонгууль ба хоригдлын эрхийн харилцан хамаарал, хязгаарлалтын шалтгааныг судлах нь хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоонд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Үүний тулд Үндсэн хуулийн үзэл баримтлал дахь хүний эрхийн ойлголт, агуулгыг судлах шаардлагатай.

I

Монгол Улсын Үндсэн хуультай зэрэгцэн манай улсад үзэл баримтлалын томоохон өөрчлөлт бий болсон билээ. Үүнийг хүний эрхийн тухай үзэл онол, хөдөлгөөн бол Монгол төрийн бодлогын дээд түвшинд буюу Үндсэн хуулийн дотор нэвтэрч, албан ёсны томъёолол болсны хувьд цоо шинэ буюу шинэхэн үзэгдэл хэмээн (Б.Чимид, 2017) үзжээ. Үүнээс үзвэл хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах асуудал бол манай улсын шинэ тогтолцооны үндсэн судлагдахуун болсон гэж ойлгож болно.

Үндсэн хуулийн үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөөг бүх хүн тэгш, хүртээмжтэй эдлэх боломжийг бүрдүүлсэн ба хүний эрхийн асуудал нь хүн хувь хүнд хамаарах субъектив зүйл болохыг онцолжээ. Тодруулбал хүний эрх, эрх чөлөөг “Төр” гэдэг “өгөөмөр” хүчнээс “хүн” гэдэг “ядмаг амьтан”-д эрх олгож (хишиг хүртээж) байгаа утгаар бус, хүнд өөрт нь байдаг болохыг хүлээн зөвшөөрсөн (Б.Чимид, 2017). Энэ бол үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний хамгийн чухал үзэл санаа бөгөөд хэн нэгэн эсхүл төрөөс хүн буюу хүний эрх, эрх чөлөө хамааралтай бус, харин төр тухайн эрх, эрх чөлөөг чөлөөтэй эдлэх баталгааг л бүрдүүлэх ёстой болохыг харуулжээ.

Иймд хүний эрхийн хязгаарлалт бол төр буюу төрийг төлөөлөгч хүмүүсийн дур зоргоороо авирласан, ямар нэг субъектив зорилгыг хэрэгжүүлэхэд ашигладаг зэвсэг биш болохыг илэрхийлжээ. Нэг үгээр бол хүний эрх бол хүн бүрийн өөрийнх нь нэг хэсэг болохоос төрөөс хамаардаг хишиг байж болохгүй Б.Чимид багш дурдсан.

Тэгвэл хүний эрхийн хязгаарлалтыг хийхдээ, зайлшгүй үндэслэл, шалтгаан хүчин зүйлийг тодруулж, үнэлсний үндсэн дээр тогтоох ёстой. Гэтэл хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхэд хандах бидний хандлага үндэслэл, шалтгаан, хүчин зүйлс мартагдаж, тогтсон хэв маяг болон хэлбэржиж байгаа нь үндсэн хуулийн үзэл баримтлалтай нэгэнт харшилж байна.

Учир нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хүнийг шийтгэж, ял зэм хүртээх нь шударга ёсонд нийцэх хэдий ч жам ёсны болон позитив эрхийн харилцан хамааралд үндэслэх учиртай. Яагаад гэвэл иргэн, төр хоёрын харилцаанд эрх илэрч, зөрчигддөг (Б.Чимид, 2017). Тэгэхээр Үндсэн хуулиар тунхаглан, бэхжүүлсэн хүний эрх, эрх чөлөөг зөрчдөг, хязгаарладаг, зохицуулдаг хууль Үндсэн хуулийн үзэл баримтлалаас гажих ёсгүй. Энэхүү утга санааг “Хууль дээдлэх үзэл бол засаг төрийг Үндсэн хуулийн болон хуулийн хязгаарлалтад оруулах тэмцэл юм” хэмээн Монгол Улсын Ардын багш Б.Чимид өгүүлжээ.

Дээрх санаанд тулгуурлан үзвэл хүний эрхийг бататган, бэхжүүлэх үйл хэрэгт улс төрийн эрх, оролцоог ихээхэн чухалчилдаг ба иргэний эрх буюу жам ёсны эрхүүдийг хэрэгжүүлэх суурь баталгаа бол улс төрийн эрх байдаг. Иймдээ ч Иргэний болон улс төрийн

эрхийн тухай олон улсын фактыг НҮБ-аас 1966 онд баталсан (МУ-ын Хүний эрхийн үндэсний комисс , 2019). Хүмүүс хэдийгээр өөрсдийн хүсэл зоригоо илэрхийлж болох хэдий ч улс төрийн баталгаа, улс төрийн шийдвэр гаргалтад нөлөөлж чадахгүй бол хүний эрх, эрх чөлөө бүрэн хэрэгжиж чадахгүйд хүрнэ. Үүнээс сэргийлэх үндсэн шийдэл бол үндсэн хууль гэдгийг бид мартаж болохгүй. Харин сонгуулиар бид дан ганц сонголт хийх бус, төр дур зоргоороо авирлахыг хазаарлаж, нийтлэг хүсэл зоригоо илэрхийлдэг.

Дээрх үзэл баримтлалаас үзвэл хүний эрхийг хязгаарлах асуудал нь зайлшгүй хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн байх ёстой ба шийдвэр гаргагчийн дур зорго байж болохгүй болох нь илхэн байна. Хүний эрхийг хязгаарлахад шалгуур их.

Товчхондоо засаг төрийн үйл ажиллагааны үндэс бол хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангах буюу бүх нийтийн хүсэл зоригийг баталгаатай эдлүүлэх, хамгаалж, хангахад л орших ажээ.

II


Илтгэлийн оршилд дурдсанчлан шударга ёс бол хүн төрөлхтний өнөөг хүртэл өгүүлж ирсэн чухал сэдэв. Харин шударга ёсыг тогтоох хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх асуудал нь сонгуультай салшгүй холбоотой. Б.Чимид багшийн өгүүлснээр төрийн эрх мэдлийг үр дүнтэй, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах зарчмыг бэхжүүлсэн эрх мэдлийн тогтолцоог бий болгох арга бол сонгуультай салшгүй холбоотой.

Учир нь эрх мэдлийг хэрхэн хуваарилж хэрэгжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлэхтэй утга нэг. Тайлбарлавал хүмүүс тэдний тодорхой хэсэг бүлэг, улмаар улс гүрэн бүхэлдээ эцсийн дүнд тухайн нийгэмдээ зонхилж буй хүсэл зоригт захирагдахыг засаг гэх ба энэ нь товчхондоо нэг нь нөгөөг хүслээрээ захирах **эрх мэдэл** юм (Б.Чимид, Сонгуульд суралцахуй , 2025). */Илтгэлийн хүрээнд цаашид эрх мэдэл хэмээх ойлголтоор “хүсэл зориг” гэх утгыг төлөөлүүлэх болно./*

Үүнийг илтгэлийн эхний хэсэгтэй холбон үзвэл иргэдийн нийтлэг хүсэл, хүний эрх, эрх чөлөөний агуулгыг өөртөө тээх ба төрийн эрх мэдэл бол хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэн хамгаалахад чиглэгдэх нь харагдаж байна. Тэгвэл сонгуулийн мөн чанар бол иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэгч эрх мэдлийг сонгон засаг төрийг үйл хэргийг залгуулах явдал гэж үзэж байна. Энэ талаар “сонгууль бол нэг хүний дарангуйллын эсрэг ард түмний засаг буюу тэдний төлөөлөгчдийн хамтын засаг тогтоохын тулд гарч ирсэн болой” (Б.Чимид, Сонгуульд суралцахуй , 2025) гэжээ. Эдгээр нь сонгууль бол ард түмний хүсэл зоригийг ард түмний төлөөлөл хэрэгжүүлэхэд чиглэсэн үндсэн зорилгыг агуулж байгааг харж болно.

Энэхүү мөн чанараас авч үзвэл сонгууль ба ардчилал хоёрын харилцан хамаарал хоорондоо гүн гүнзгий болохыг ойлгож болно. Яагаад гэвэл манай улс 1992 оны үндсэн хуулиараа “... ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго” болгосон ба ардчилал бол бидний нийгмийн хөгжлийн үндсэн загвар болох нь тодорч байна. Харин сонгууль бол ардчиллыг бэхжүүлэгч гэж үзэж байна. Уг хамаарлыг Б.Чимид багш “Ардчилал хумигдвал сонгууль сульдана доройтож, дарангуйлагч бүлгийн гарын зэвсэг болдог” (Б.Чимид, Сонгуульд суралцахуй , 2025) хэмээн хэлсэн нь хүний эрх, ардчилал, сонгууль хэмээх гурвалжны амин чухлыг өгүүлжээ.

Зураг 1. Хүний эрх, ардчилал, сонгуулийн хамаарлын холбоо



Хүний эрх бол ард түмний хүсэл зоригийг илэрхийлэгч бол сонгууль нь тэрхүү хүсэл зориг хэрхэн эрх мэдэл болон хэрэгжихийг тодорхойлж байна. Харин ардчилан бол эрх мэдлийг хэрэгжүүлэхэд бүх ард түмний оролцоог хангах хэрэгсэл гэж үзэж байна. Иймд оролцоо хумигдвал ард түмний хүсэл зориг бүрэн илэрхийлэгдэхгүй ба тэрхүү орон зайг дарангуйлагч бүлэг эзлэхэд хүрнэ.

Засаг төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай, энэ эх сурвалжийг тээгч төлөөлөгч, засаг төр нь ард түмнийхээ төлөө үр нөлөөтэй, бүтээмжтэй ажилладаг хэлбэрийг ардчилсан хэмээн үзсэн (Н.Лүндэндорж, 2024). Ардчилсан ёс бол асуудлыг хянаж шийдвэрлэхдээ ганцаар захирах, шийдэх ёсыг бус олонхын саналыг харгалзаж, шийдвэр гаргах (О.Мөнхсайхан, 2022) хэмээн үзсэнээс таны оролцоо, санал шийдвэр гаргалтад нөлөөлдөг болохыг дурдсан байна. Эдгээр тайлбараас ардчилал хэмээх ойлголтоос “оролцоо” гэх агуулгыг илтгэлийн хүрээнд онцолж байгаа дурдах нь зүйтэй.

Тэгвэл ардчилсан сонгууль бол ард түмний оролцоог бүрэн хангасан, тэдний хүсэл зоригийг илэрхийлэгч эрх мэдлийг сонгон хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм.

Илтгэлд дурдсан хоёр хэсгийг нэгтгэн үзвэл хүний эрх, сонгууль хэмээх ойлголтууд нь нийгмийн ямар ч байгууллын үед хөндөгддөг асуудал болохыг дурдах хэрэгтэй. Угтаа бол хаант засаглалын үед ч тэр хүний эрхийг хангах, хамгаалах асуудал хөндөгдөж байсан хэдий ч хамгийн чухал асуудалд тооцоогдоогүй байна. Харин ардчилсан нийгмийн үед хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах асуудлыг чухалчлах ба сонгууль бол иргэдийн хүсэл зориг, оролцооны илэрхийлэл болдог онцлогтой юм.

III

Ардчилсан сонгуулийн гол зарчим бол иргэдийн оролцоог бүрэн хангасан, чөлөөт сонголтод тулгуурласан байх ёстой. Энэ ч утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлд “Монгол Улсын иргэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” хэмээн тунхаглан зарласан. Ингэхдээ энэ эрхийг “баталгаатай” эдлэх тухай дурдсан. Баталгаа гэдэг бол дэг журмыг хангах зарчим, хүчин зүйл, арга хэрэгслийг илэрхийлэх (Н.Лүндэндорж, 2024) ба эрхээ хэрэгжүүлэхдээ байгаль, нийгмийн хүчин зүйлсийн болзошгүй сөрөг нөлөөллөөс хууль болон бусад арга хэрэгслээр хамгаалагдсан байх (Залуу судлаачдыг дэмжих сан, 2025) агуулгыг илэрхийлж байна.

Тэгэхээр үндсэн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхтэй айх айдасгүй, эмээх зүйлгүйгээр, хэрэгжүүлэх, хэн нэгэн хүн, аливаа хүчнээс үл хамааран эрх эдлэх утгыг агуулж байна. Харин энэ эрхээ эдлэхэд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хязгаарлалт тогтоох ба ингэхдээ хуулиар зохицуулахыг заасан.

Товч дүгнэвэл Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө ямар нэгэн ялгаварлалгүйгээр баталгаатай хэрэгжих ёстой ба энэ зарчим хорих ял шийтгүүлсэн хүмүүст ч нэгэн адил үйлчлэх ёстой. Хоригдол ч гэсэн Монгол Улсын иргэн тул дээрх эрхээ баталгаатай эдлэх ба ардчилсан сонгууль бол ард түмний оролцоог хангах зарчимд тулгуурлана.

Тухайлбал хоригдлын улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж байгаа ба энэ нь тухайн хорих ангид хорих ялыг эдлүүлэх шаардлагатай буюу гагцхүү хорих ангид хүнийг тусгаарлаж байгаатай холбогдуулах хязгаарлагддаг эрх байна. Мөн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, эрхтэй хэдий ч хорих ангид амьдарч байгаатай холбогдуулан хорих ангид хийж болох ажлуудаас сонгохоос өөр аргагүй юм. Энэ мэтчилэн хорих ангид амьдарч байгаа нь тухайн хүний эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа бөгөөд үүнтэй холбоотой хоригдолд бий болж байгаа эрхийн хязгаарлалтууд л гагцхүү эрүүгийн хариуцлагын зорилгод тусгасан цээрлүүлэлт болох ёстой.

Учир нь ихэнх судлаачдын үзэж байгаагаар эрүүгийн хариуцлага хүлээхтэй холбоотой гэмт этгээдийг цээрлүүлэх ёстой гэж үздэг. Гэсэн хэдий ч тэрхүү цээрлүүлэлт нь субъектив шинжтэй байж болохгүйн дээр хүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох зорилго агуулж болохгүй. Тэгэхээр зөвхөн эрхийн хязгаарлалтаар дамжуулан ялын цээрлүүлэх зорилгыг хангадаг болохыг бид анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл 6 сараас 25 жилийн хугацаанд хорих ангид амьдрахтай холбогдуулан үндсэн хуульд заасан эрхүүд нь хязгаарлагдах байдлаар хорих ялын цээрлэл биеллээ олдог гэсэн үг.

Гэхдээ эрхийн хязгаарлалт нь хүнийг цээрлүүлэхэд чиглэгдэх ёсгүй. Нарийвчлан тайлбарлавал хорих ял эдэлж байгаа хүнийг шаналгахын тулд гэр бүлээс нь хол хорих ангид хорьдог биш, хорих ял эдэлж байгаа хүний сэтгэлийг өвтгөхийн тулд сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийг хасдаггүй гэдгийг санах хэрэгтэй. Угтаа бол тухайн гэмт этгээдийг нийгэмд зөв амьдрахад бэлтгэх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн зан үйл, хандлагыг засан сайжруулаад нийгэмд эргүүлэн оруулахын тулд хорих ангид хорьдог ба ингэж хориход саад учруулах, энэ мөн чанарыг алдагдуулах эрхийг л хязгаарладаг юм.

Зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн бөгөөд нийгмийн дунд байх нь олон нийтийг аюулд учруулж болзошгүй учир тухайн гэмт этгээдийг хорих ангид тусгаарладаг нь үндсэн хуульд заасан хүний эрхийг хязгаарлах үндэслэлд хамаарч байна. Тэгвэл үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийг хоригдолд хязгаарлах н мөн үндэслэлд хамаарах ёстой. Учир нь Монгол Улсын Үндсэн хууль бол бидний бүтээсэн шударга ёс, бөгөөд энэ шударга ёсны үзэл санаанд нийцүүлэн бусад хууль бүтээгдэх учиртай. Ингэснээр үндсэн хуулийн агуулга, үзэл санааг зөрчсөн хуулийг хэрэглэхгүй ба үүнийг шударга бус хууль гэж үзэж үндэстэй юм.

Тэгвэл үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт дараах эрхүүдийг заасан байдаг.
/Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох

эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ./ Үүнд:

- Төрийг удирдах хэрэгт шууд оролцох эрх
- Төрийг удирдах хэрэгт төлөөлөгчдийн байгууллагаа уламжлан оролцох буюу шууд бусаар оролцох эрх
- Өөрөө төрийн байгууллагад сонгогдох эрх
- Төрийн байгууллагад ажиллах хүнийг сонгох эрх зэргийг хамааруулсан.

Тэгвэл хорих ял эдэлж байгаа хүн дээрх 4 эрхийг хэрэгжүүлснээр үндэсний болон амын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалахад ямар эрсдэл бий болгож байгаа дүгнэе.

1. Төрийг удирдах хэрэгт шууд оролцох эрх

Нийтлэг эрх ашиг гэдэг нь хувь этгээд дангаар хамгаалж, хэрэгжүүлэхэд хүч үл хүрэх, хүн бүрт хамаатай асуудлыг хамааруулна (Н.Лүндэндорж, 2024) гэсэн ба өөрөөр тайлбарлавал төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхтэй холбоотой харилцаанд өөрөө бие даан оролцож, хяналт, тавих, шаардах, хуульд заасан хэлбэрээр нөлөөлөх цогц арга хэмжээ юм. Тэгвэл хорих ял эдэлж байгаа хүмүүс өөрөө, бие даан шууд оролцож, хяналт, тавих, шаардах боломж нь хорих ангид ял эдэлж байгаатай нь холбогдуулан тухайн хугацаанд хэрэгжих **боломжгүй** байна.

Нөгөөтээгүүр хоригдлуудын шууд оролцох боломжийг нээх нь нийгмийн хэв журмыг алдагдуулах буюу шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгүүлсэн этгээд бүрэн нийгэмшээгүй буюу нийгэмд эргэн нэгдэхэд болоогүй байхдаа уг харилцаанд оролцох нь дахин гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл бий болгож болно.

2. Төрийг удирдах хэрэгт төлөөлөгчдийн байгууллагаа уламжлан оролцох буюу шууд бусаар оролцох эрх

Шууд бус оролцоог бүх нийтийн санал асуулга, сонгууль зэргээр зэргээр хязгаарлахгүй ба нийгмийн гэрээний онолын үүднээс дуутай, дуугүй зөвшөөрч, эс зөвшөөрч байгаа иргэний бүх оролцоог хамруулан ойлгоно гэжээ (Н.Лүндэндорж, 2024). Нөгөө талаас төрийн бүх шатны байгууллагаар дамжуулан тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, шаардах, хуулиар зөвшөөрөгдсөн арга хэлбэрээр нөлөөлөхийг шууд бусаар оролцох гэж үзэж болохоор байна (Залуу судлаачдыг дэмжих сан, 2025). Тиймээс хорих ял эдэлж байгаа хүмүүс үндсэн хуулийн агуулгаар төрийг удирдах хэрэгт шууд бусаар оролцдог байх нь.

3. Сонгогдох эрх

18 наснаас буюу иргэний хуульд зааснаар эрх зүйн бүрэн чадамжтай болсон үеэс төрийн байгууллагад сонгогдох, сонгох эрх нээгддэг. Сонгогдох гэдгийг тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд өөрт давуу байдлыг үүсгэсэн шинжээрээ бусдаас ялгаран тодорхойлогдох ойлголт бөгөөд үндсэн хуулийн 19.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагад өөрийн давуу шинжээрээ бусдаас тэргүүлэн ажиллах ойлголт юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай фактад сонгох, сонгогдох эрхийг арьс үндэс, хүйс, хэл, шашин, үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэх хангах үүрэгтэй болохыг заасан ба Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаатай ч утга нэг юм.

Харин хорих ял эдэлж байгаа хүн хорих ангид амьдарч байгаа, чөлөөтэй зорчих, өөрийн болон бусад хүмүүсийн эрх ашгийг бүрэн төлөөлөх боломжгүй нь тухайн иргэнийг төрийн байгууллагад сонгогдох эрхийг хязгаарлахад хүргэж байна. Мөн хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хөдөлмөрлүүлэх ажиллагаа нийгэмшүүлэх зорилгод чиглэдэг тул нийгэмшүүлэх зорилгыг хангахгүй ажил хийлгэх нь ялын мөн чанарт үл нийцнэ.

Сонгогдсон төрийн байгууллагад ажиллах ёстой ба тус ажил нь хувийн бус нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх ёстой. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх хүнд шаардлагатай хэрэгцээг хангах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжоор хэрэгжүүлдэг нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго, хорих ял эдлүүлэх дэглэм, нөхцөлд харшилж байгаа нь хоригдлын сонгогдох эрхийг хязгаарлах шалтгаан болж байгааг бид ойлгох хэрэгтэй.

Жишээ нь төрийн албан тушаалд ял шийтгэл эдэлсэн эсхүл, ял шийтгүүлсэн байх асуудал нь төрийн зарим албан тушаалын тусгай шаардлага байдаг болохыг санах хэрэгтэй (УИХ-ын Тамгын газар, Төрийн албан тухай хууль, 2017). Энгийнээр хэлбэл ял шийтгэлийн цээрлэл нь эрхийн хязгаарлалтад орших ба тэрхүү эрхийн хязгаарлалт нь тухайн ялын мөн чанар, зорилгоор тодорхойлогддог. Иймд төрийн зарим албанд ял шийтгүүлж байсан эсхүл ял шийтгүүлсэн хүн ажиллах боломжтой байдаг шүү дээ.

4. Сонгох эрх

Хэн нэгэн этгээд өөрийгөө төлөөлөн эрх мэдэл хэрэгжүүлэх боломж юм (Н.Лүндэндорж, 2024). гэжээ. Үүнээс гадна төрийн байгууллагад сонгох эрхийг үндсэн хуулийн 19.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагад ажиллахаар нэр дэвшсэн хүнийг сонгож санал өгөх боломж гэж тодорхойлсон (Залуу судлаачдыг дэмжих сан, 2025). Тэгвэл хорих ял эдэлж байгаа хүн өөрийгөө төлөөлөх хүнд боломж олгох эрхтэй байх нь дамжиггүй. Энэ нь “төрийг удирдах хэрэгт, төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан оролцох, шууд бусаар оролцох эрхтэй” шууд хамааралтай тул хорих ял эдэлж байгаа иргэнд мөн адил үйлчлэх боломжтой болох нь харагдаж байна.

Нөгөө талаас эрүүгийн хуульд заасан олон төрлийн гэмт хэрэг нь үйлдлийг тодорхойлдог ба тодорхой үйлдэл нь хүний эрхийг хавтгайруулан хязгаарлах шалтгаан болж болохгүй билээ.

Хорих ял эдэлж байгаа хүн төрийн байгууллагад нэр дэвшиж байгаа хүнийг сонгох үйл явц нь үндэсний болон, хүн амын аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалахад харшлах зүйл ажиглагдахгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй. Түүнчлэн илтгэлийн II хэсэгт өгүүлснээр ардчилсан сонгууль бол иргэдийн оролцоог бүрэн хангах боломжийг эрэлхийлэх зарчимтай билээ. Хорих ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцсоноороо үндэсний аюулгүй байдалд эрсдэл хэрхэн учрахыг тайлбарлах аргагүй юм. Мөн хорих ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцсоноороо нийгмийн дэг журам хэрхэн эрсдэхийг тайлбарлах арга байхгүй.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (УИХ-ын Тамгын газар, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль, 2019), Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиудаар хорих ял эдэлж байгаа хүний сонгох эрхийг хязгаарлажээ. Эдгээр нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний заалт хийгээд түүний үзэл баримтлалыг, мөн хуулийн үзэл баримтлалд тодорхойлсон ардчилсан сонгуулийн суурь зарчмуудыг тус тус зөрчиж байна.

Дүгнэлт

Хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуульд оролцох, түүний хэрэгжилт сэдэвт илтгэлийн хүрээнд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

1. Монгол Улсын 1992 оны “Ардчилсан” Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөнд хандах хандлага, үзэл санааг цоо шинэ шатанд гаргажээ. Иймд манай улсын хөгжил, нийгмийн зорилт бол хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хамгаалж, хангасан байх бөгөөд засаг төрийн эрх мэдэл нь уг зорилгод чиглэсэн байх ёстой ажээ.

Харин энэ үйл хэрэгт нийт ард түмний оролцоо чухал болохыг Б.Чимид багш эрхэмлэн онцолсон ба эрх мэдлийг хэрэгжүүлэх, эрх мэдлийн хуваарь, хяналтад иргэдийн оролцоо чухал ба энэ нь төрөөс бус харин иргэдээс хамааралтай байх зүй тогтолтой юм. Тэгэхээр Үндсэн хуулийн үзэл баримтлалаар иргэдийн эрх, хүсэл зориг бол ардчилсан сонгууль юм.

2. Үндсэн хуулийн үзэл баримтлал Монголын бүх ард түмэнд хамааралтай бөгөөд ямар нэг ялгаваргүйгээр хүн бүрт энэхүү үзэл баримтлалын хүрээнд хүмүүжиж, өсөх, ажиллаж, амьдрах хэрэгтэй.

Ардчилсан сонгууль бол манай улсын үндсэн хуулийг тулгуур багануудыг нэг болохыг илтгэлийн судалгаанаас дүгнэж болно. Учир нь ардчилсан сонгуулийн дүнд засаг төрийн эрх мэдэл хүний эрх, эрх чөлөөг бататган, бэхжүүлэхэд чиглэгддэг ба хүний эрх, сонгууль, ардчилал гурав нийгмийн хөгжлийн циклийг хөдөлгөж байна.

Ардчилсан сонгуулийн үнэт зүйл бол бүх ард түмний чөлөөт оролцоог илэрхийлэх ёстой.

Эдгээрийг үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын гэрээний агуулгад тулгуурлан дүгнэж байна.

3. Гэсэн хэдий ч нийгмийн зарим хэсэгт дээрх үзэл баримтлал, үнэт зүйл бүрэн хэрэгжиж чадахгүй байна.

Хорих ял хийгээд хорих ял эдлүүлэх ажиллагаа бол нийгмийн сайн сайхны төлөө зарим хүмүүсийн эрхийг хязгаарлах замаар тэднийг засан сайжруулж нийгэмд эргэн нэгтгэдэг өвөрмөц ажиллагаа юм. Иймд хорих ялын зорилго, мөн чанар нь өөртөө хүний эрхийн тодорхой хязгаарлалтуудыг дагуулдаг ба энэ нь цээрлүүлэлт гэхээсээ илүүтэй “**боломжгүй**” гэдэг үгээр тодорхойлогддог болохыг анхаарах хэрэгтэй.

Хоригдлын сонгуульд оролцох эрхийн хязгаарлалт нь үндэслэл бүхий шалтгаанаар тайлбарлагдах ёстой. Ингэж гэмээнэ ардчилсан үндсэн хуулийн үзэл баримтлал хүн бүрт тэгш үйлчлэх болно.

Сонгуулийн тухай хуулиудаар хорих ял эдэлж байгаа хүмүүсийн сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлал, ардчилсан сонгуулийн үнэт зүйл харшилж байна гэж дүгнэж байна.

Харин хоригдлын сонгуульд оролцох эрхийг хязгаарлах шалтгаан нь хоригдлын үйлдсэн гэмт хэрэг ба сонгуульд оролцох эрхэд харшлах, эсхүл энэ эрхийг хязгаарлахад хүргэж байгааг хүлээн зөвшөөрөх үндэслэлтэй.

Санал

1. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгын хүрээнд хууль сахиулах байгууллага тэр дундаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад мэдээлэл түгээх, тэднийг соён гэгээрүүлэх, үндсэн хуулийн боловсрол олгох шаардлагатай байна.

Учир нь Монгол Улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх ажиллагааг 104 жилийн турш зохион байгуулж байгаа ууган байгууллага хэдий ч Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хоригдлын эрх зүйн байдлыг тогтоох, зохион байгуулах хандлага, чадамж сул байна.

2. Ардчилсан сонгуулийн үнэт зүйлийг хадгалах хүрээнд хорих ял эдэлж байгаа иргэдийн бүх шатны сонгуульд оролцох эрхийг сэргээн эдлүүлэх хүрээнд судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлэх. Эрдэм шинжилгээ, практик ажлын эргэлтэд оруулах шаардлагатай.

3. Сонгуулийн хуулиуд¹ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хорих ял эдэлж байгаа иргэдийн сонгуульд оролцох эрхийн баталгааг бүрдүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материалын жагсаалт

Чимид, Б. (2017). *Үндсэн хуулийн үзэл баримтлал*. Улаанбаатар хот.

Чимид, Б. (2025). *Сонгуульд суралцахуй*. Улаанбаатар: Чимид сан.

Залуу судлаачдыг дэмжих сан. (2025). *Хүний эрхийн нэр томъёонд системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс. (2019). *Хүний эрхийн олон улсын билл*. Улаанбаатар.

Лүндэндорж, Н. (2024). *Монгол Улсын Үндсэн хуулийн шинэслэх ухааны тайлбар*. Улаанбаатар: Адмон принт.

Мөнхсайхан, О. (2022). *Үндсэн хуулийн хяналт ба тайлбар (Үндсэн эрх)*. Улаанбаатар.

УИХ-ын Тамгын газар. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

УИХ-ын Тамгын газар. (2017). *Төрийн албаны тухай хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

УИХ-ын Тамгын газар. (2017). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

УИХ-ын Тамгын газар. (2019). *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

УИХ-ын Тамгын газар. (2021). *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

УИХ-ын Тамгын газар. (2020). *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль*. Төрийн мэдээлэл эмхэтгэл.

Өнөболд, Э. (2021). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүсэл, хөгжлийн түүхэн товчоон*. Улаанбаатар: Адмон принт.

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2020, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль. 2019, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. 2020.